



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 21 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

### Сургалтад хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.6.1 дэх заалтын Г хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Гантуулгын Даваамөнх, Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Battmöröriйн Anujin нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад хамруулсугай.

2. Сургалтын төлбөрийг 3,510,000 (гурван сая таван зуун арван) мянган төгрөгөөр тооцож холбогдох зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА